

М.Ганди, түүний шашны философийн онцлог

Р.Дарьхүү- МУИС.НШУС.Философийн тэнхмийн эрхлэгч, профессор
Г.Эрдэнэбаяр. МУИС.НШУС.Сургалтын албаны эрхлэгч, доктор

Түлхүүр үг: бурхан, үнэн, хайр, сатьяграха, ахимса, ёс суртахуун

Товч утга: Энэхүү өгүүлэлд орчин үеийн энэтхэгийн философийн нэрт төлөөлөгч М.Ганди, түүний үйл ажиллагаа ба шашны философийн гол зарчим, ойлголт, үндсэн баримтлалын онцлогийг задлан шинжилж тайлбарлахыг зорьсон болно.

М.Ганди (Mahatama Gandhi) /1869 – 1948/ нь вайши гэр бүлд төрсөн бөгөөд Энэтхэгийн нийгэм-улс төр, шашны зүтгэлтэн юм. Тэрээр 1888-1891 онд Англид хуулийн мэргэжлээр суралцаж, эх орондоо буцаж ирээд, өмгөөлөгчөөр ажиллаж байгаад, дараа нь Өмнөд Африкт ажиллаж, тэнд Европчуудын арьс өнгөөр ялгаварлах дарангуйллыг биеэр мэдэрч, улмаар сатьяграха онолоо боловсруулжээ. 1914 онд М.Ганди гадаадаас эх орондоо эргэн ирж, Английн колончлолын эсрэг үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэлд идэвхитэй оролцож, үймээн дэгдээсэн хэргээр 6 жилийн хорих ял авчээ. Гэвч тэрээр эрүүл мэндийн улмаас шоронгоос гарч, Энэтхэг улс тусгаар тогтнолоо олтол гэртээ харихгүй гэж тангараглаж явжээ. 1947 онд Энэтхэг тусгаар тогтнолоо олж, М.Ганди 1948 оны 1 сарын 30-нд эмгэнэлтэйгээр амиа алдсан түүхтэй.

Түүний философийн гол баримтлал нь үнэнд тулгуурлах, хүчирхийлэлгүй байх, Энэтхэгийн тусгаар тогтнолыг тайван замаар олох, бүх хүнийг шашин, каст, анги ялгахгүй эх орныхоо төлөө тэмцэлд нэгтгэх, иргэдийн ёс суртахууныг төгөлдөржүүлэх үзэл юм.

Тэрээр өөрийн философийн онцлогийн талаар өгүүлэхдээ: “Би шинэ онол ба зарчим гаргахыг эрмэлзээгүй, гагцхүү мөнхийн үнэнг ердийн амьдралд хэрэглэхийг оролдсон юм. Үнэн ба энэрэнгүй сэтгэл хоёр нь энэ дэлхий дээр амьдрал үүссэнээс хойш бий болсон юм. Миний философи энэ хоёр зарчим дээр тулгуурлаж байна” гэжээ.

Түүний **философийн гол зарчим** нь бурханыг бүхнээс анхдагч хэмээх зарчим юм. Түүний үзлээр, “Бурхан бол хүн биш, бурхан бол хүч. Энэ нь амьдралын мөн чанар юм. Тэр нь цэвэр бөгөөд ариун ухамсар юм. Тэр нь мөнхөд оршино. Бурхан бол үнэн ба хайр юм. Бурхан бол эр зориг ба аймшиггүй юм. Бурхан бол гэрлийг цацруулагч, амьдралын эх үүсвэр юм. Гэхдээ бурхан бол энэ бүгдээс дээгүүр оршдог, энэ хүрээнээс хальсан зүйл юм. Тэр нь хэл ба оюун ухаанд багтахгүй тийм зүйл” ажээ. М.Ганди өөрийн ертөнцийг үзэх үзлийн талаар хэлэхдээ: “Бурханы тухай би өөрөө итгэж байгаагаараа л ярина. Ухамсар ба оюун ухаан нь бурханыг танин мэдэж чадахгүй. Атеист намайг ялан дийлтлээ маргасан ч, миний итгэл нь миний оюун ухаанаас хэд дахин илүү байна. Ийм болохоороо би бурхан байна, байх ч болно гэж үзэж байна” гэсэн буй.

Ийнхүү тэрээр үнэнийг бурханы зэрэгт аваачиж, үнэнд итгэх, үнэнийг шүтэх хэрэгтэй гэсэн санааг дэвшүүлжээ. Түүний үзлээр, “Үнэн зөвхөн амнаас гардаг үг байх ёсгүй, үнэн бол аманд ч, үзэл санаанд ч, үйл ажиллагаанд ч адил тэнцүү яв цав тохирох ёстой.” хэмээн үнэнийг шашны болон ёс суртахууны агуулгаар авч үзээд, улмаар улс төрийн үзэл баримтлалынхаа үндэс болгосон

байна. М.Ганди үнэнийг туйлын ба харьцангуй үнэн хэмээн хоёр төрөлд ангилж үзжээ. Туйлын үнэнийг хэн ч олж чадахгүй, энэ нь өдөр бүр бага багаар дэлгэрч гарч ирдэг бөгөөд зөвхөн “дотоод намуун дуу”-гаар илэрч бидэнд сонсогддог байна. Энд оюун ухаан, мэдрэхүйн эрхтний оролцоо хэрэггүй. Харьцангуй үнэн нь жирийн амьдрал дотор, бидний ухамсарт байдаг үнэн юм. Туйлын үнэнд хүрэх гол арга зам нь хүчирхийлэлгүй байх явдал юм.

М.Ганди ёс зүйн сургаалдаа жайнизмийн гол зарчим болох “ахимса” буюу амьтай бүхэнд хор хүргэхгүй байх зарчмыг уламжлан хөгжүүлсэн буй. Түүний үзлээр, “Хайрлах ба өширхөх сэтгэл нэг газар хамт байж чадахгүй. Энэ хоёрын аль нэг нь байгаа цагт нөгөөх нь тэнд орших боломжгүй. Зовлон бол эрх чөлөөнд хүрэх нэг нөхцөл. Хүн чөлөөтэй, юунаас ч хараат бус амьдрая гэж бодож байгаа бол ариун шударга амьдрах урлагт суралцах хэрэгтэй. Үнэн, хайр, хүчирхийлэлгүй байх гэсэн гурван ойлголт дээр тэрээр өөрийн философийн үзлээ нэгтгэн, сэтгэлээрээ бүхнийг бүтээх чадвар хүнд байдаг гэсэн санааг дэвшүүлсэн байна.

Англид их сургуульд сурч байхдаа М.Ганди барууны соёл, шинжлэх ухаан, аж төрөх ёс зэрэг олон зүйлтэй танилцаж байв. Өмнөд Африкт байхдаа тэрээр цагаан арьстнуудын арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл, хүчирхийллийг нүдээр үзэж, тэр үеэс өөрийн Сатьяграха үзлийг боловсруулж эхэлжээ.

М.Ганди нь өмнөд Африкт ажиллаж амьдарч байсан үеийн улс төрийн туршлагаасаа дүгнэлт хийн, Сатьяграха буюу Хүч үл хэрэглэх зарчмын дагуу Энэтхэгийн тусгаар тогтнолын төлөө ажиллахаар шийджээ. Сатьяграха амьдралын жижиг асуудал төдийгүй улс төрийн боолчлол зэрэг томоохон асуудлыг хүртэл шийдэж чадах юм хэмээн тэрээр үзэж байв.

М.Гандигийн үзэл санаа бүрэлдэн тогтоход эртний Энэтхэгийн уламжлалт шашин ихэд нөлөөлжээ. Тэрээр энэтхэгийн шашны бүтээлүүдийг бага байхдаа уншиж байсан нь түүнд ихэд нөлөөлсөн төдийгүй Англид сурч байхдаа Христосын болон Мусульман шашны номлолыг шимтэн сонирхож байв. Мөн Толстойн бүтээлүүдийг судалсан нь түүний Сатьяграхын үзэл бүрэлдэн тогтоход томоохон нөлөөлсөн байдаг. М.Ганди хэдийгээр мэргэжлийн философич биш боловч түүний гэр бүлийн нөлөө болон Вайши нарын уламжлалт соёл түүний тейст үзэл санааг төлөвшүүлсэн байна. Энэтхэгийн Вайши нарын уламжлалт соёл нь ведийн болон упанишадын сургаалийг голлон баримталдаг юм. Вайши нар ертөнцийн бодит байдал хийгээд бүтээгч бурханд итгэдэг. Бурхан мэдэгдэж, мэдрэгдэж байх ёстой бөгөөд тэдний үзлээр, мэдрэх болон сүсэглэх нь авралыг олох цорын ганц арга зам юм.

Түүний үзлээр, “Бурхан зөвхөн оюун санааны сонирхол, сэтгэл ханамжийн тулд бус, мөн хүч чадал, тайвшралын эх үндэс байх ёстой. Бурханд итгэх сэтгэл нь аливаа хүнд тайван амьдрах боломжийг олгох ёстой. Зөвхөн оюун ухааны хэрэгцээг хангаж байвал тэр бурхан биш. Бурхан байхын тулд зүрх сэтгэлийг удирдан чиглүүлэгч байх ёстой. Энэ нь дотоод сэтгэл санааны ертөнцийн холбоо бөгөөд бурханыг хүнээр төсөөлж байх үед буюу бүхий л сэтгэлээрээ мэдэрсэн үед боломжтой юм”.

Бурхан бол Үнэн. Энэ асуудлыг шийдвэрлэх нь Гандигийн философийн үзэл санааны эх болдог. Тэрээр хэлэхдээ: “Би бага залуу байхдаа Хинду шастирууд дахь олон бурхдын нэрийг уншдаг байлаа. Гэвч бурхны эдгээр олон нэрс эцэстээ бурхан нь нэргүй, хэлбэргүй гэдгийн илэрхийлэл. Иймд Үнэн бол бурхан юм. Учир нь бурхан бол цор ганц бодит зүйл. Үнэн бол бурхны атрибут биш, харин Бурхан бол үнэн юм. Хожим тэрээр бурхан бол үнэн гэсэн баримтлалаа үнэн бол бурхан гэсэн утгаар сольжээ. Учир нь хүн бүр бурхан гэдэг үгийг пантейст, тейст, политейст, дейст зэрэг олон янзаар ойлгодог. Харин

Үнэн гэдэг бол ямагт өөрийн ач холбогдлын хувьд ойлгомжтой байдаг. Бурхны талаархи шашны үзэл санаа хүн төрөлхтнийг төөрөгдүүлж болох авч үнэн бол хамгийн чухал зүйл гэжээ.

М.Гандигийн хувьд үнэн бол өөрийгөө гэрэлтүүлэгч зүйл юм. Тэрээр үнэний талаархи эдгээр олон утгуудыг нэгтгэж, Үнэнийг Бурхантай адилтгасан байна. Тэрээр Сат хэмээх үгнээс гаралтай Сатъя гэх ойлголтоор бодит байдлыг тэмдэглэжээ. Ийнхүү тэрээр үнэнийг бодит байдалтай адилтгажээ. Түүний философийн "Үнэн бол бурхан" гэсэн үгэнд прагматик хийгээд шашны үзэл санаа агуулагддаг. Энэ нь итгэл сүсгийн объект бол бурхан биш, харин Үнэн байдаг. Иймд энэ нь универсал шашны үндэс болж байна, учир нь үнэнд итгэх явдал бол бүх каст, үндэстнийг ялгалгүй хамардаг ажээ. Шашныг үгүйсгэдэг болон шашинд итгэдэг хэн боловч эцсийн дүндээ үнэний өмнө бүгд нэгддэг хэмээгээд, "Үнэн бол бурхан" хэмээх тодорхойлолтыг тэрээр өгчээ.

Түүний үзлээр, энэ ертөнцийг захирч байдаг хууль байдаг. Энэ ертөнцөд зохицол, дэс дараалал бүхий хууль байх бөгөөд хэн нэгэн тэрхүү хуулийг өгсөн гэж үзэх нь түүний үзэл санааны хувьд бурхны оршин байхуйн талаархи телеологи баталгаа гэж үзэж болно. Дараа нь тэрээр ёс суртахууны нотолгоог гаргаж ирсэн. Ухамсар гэдэг нь сайн мууг ялгаж байдгаараа хүнийг тодорхойлж байдаг гол зүйл. Хүн ямарваа муу зүйлийг хийхдээ сэтгэл зовниж, сайн зүйл хийхдээ сэтгэл амарч байдаг нь хүний дотоодод ухамсар сэтгэл байдгийг илэрхийлж, түүний үүрэг хариуцлагыг мэдрүүлж байдаг.

Бурханд итгэж үнэмших сүсэг бишрэл хүний амьдралд хэрэгтэй. Бид өөрсдийн амьдралыг судалж үзвэл, бид ямагт материаллаг зүйл хүсч, улмаар үүнийхээ хязгааргүйг мэдрэн яваандаа оюун сэтгэлийн ханамжийг шаардах тэр үед бурхан бидэнд тэрхүү ханамжийг буюу хайр, хүч, тайван, аз жаргалыг өгдөг. Хайрын тэрхүү объект нь харин бурхан байдаг. Итгэл бишрэлийг батлах гадаад туршлага бололцоогүй бөгөөд хайр, үнэний хууль зэрэг ёс суртахуунд итгэх нь бидэнд хэрэгтэй гэсэн үндэслэлийг гаргажээ.

"Үнэн бол Бурхан" гэсэн үндсэн итгэл үнэмшил ажиглагддаг. М.Гандигийн үзлээр, бурхан бүх зүйлст агуулагддаг. Энэ талаар тэрээр хэлэхдээ: "Бүх зүйлд түгээмэл орших нууц хүч чадал байдаг. Би үүнийг хардаггүй боловч мэдэрдэг. Энэ үл үзэгдэх хүч нь миний мэдрэхүйгээр хүртдэг бүх зүйлсээс ондоо байдаг" гэжээ.

Бурхан бол "Хайр" гэж тэрээр хэлсэн байна. Бурхны утга учир нь Хайр ба Ахимса гэсэн түүний үзэл баримтлалаас тодорхой харагддаг бөгөөд хайрын тухай ойлголтыг мэдрэх нь бурхныг ойлгож буй хэрэг юм. Бурхан бид бүгдийн дотор байдаг, тиймээс бид хайрлах зан чанараа эрхэмлэснээр бие биенээ болон бурхныг хайрладаг. Энэ хайр нь бусдын сайн сайхны төлөө өөрийг золиослохыг шаардаж байдаг.

Философийн түүхэнд хүний байр суурь болон уг чанарын талаарх асуудлыг сонирхон өөрийн санаа бодлоо дэвшүүлэн ирсэн олон сэтгэгчид байдаг. М.Ганди хүнийг тодорхойлж ирсэн өмнөх үеийн тайлбаруудыг хангалтгүй гэж үзээд, энэ нь хүний гадаад харагдах зан төрх, үйлдлийг илэрхийлсэн болохоос бус, жинхэнэ үнэнийг нээж чадаагүй хэмээн шүүмжилсэн буй. Гэхдээ энэ нь хүн гадаад байдлаараа бодитой бөгөөд дотооддоо хуурамч хоосон гэсэн үг биш. Социологи, сэтгэл судлаачдын орхигдуулсан гол мөн чанар бол хүн угтаа иж бүрдэл амьтан гэдэг зүйл. Махбод бүхий хүн бол харагдах байдал төдийгүй байгалийн нэг объект. Энэ махбод өсөж төлжиж, байгалийн хуулиар нэгэн цагт үгүй болно. Энэ нь түүний физик чанарыг илэрхийлж байна. Харин хүн бол зөвхөн физик биет бус, түүнд физикийн бус олон шинж байдаг. Хүнд ухамсар, оюун ухаан, сэтгэхүй, хүсэл, сэтгэл хөдлөл зэрэг олон чанарууд байдаг. Мөн сайн муу, сайхан муухайг ялгах үнэлэмж бий. Энэ бол физикт байдаг зүйл биш. Энэ бол түүний сүнс сэтгэл буюу

жинхэнэ мөн чанарыг илэрхийлж буй зүйл юм. Гандигийн энэхүү тайлбар бол түүний философийн нэг хэсэг юм.

Тэрээр хүн уг чанараараа сайн, хэдийгээр хүн гаднаа зэрлэг, бүдүүлэг, муу байвч угтаа түүний дотоодод нь сайн сайхан агуулагдаж байдаг. Иймээс Хүч үл хэрэглэх зарчмыг хүн бүрт хэрэгжүүлэх бололцоотой. Энэхүү хүн бүрийн сайн сайхны төлөө гэсэн сэтгэл нь хүн төрөлхтнийг нэгэн дээвэр дор нэгтгэж чадна. Бид хэдийгээр олон боловч зүрх сэтгэлээрээ нэг. Нар хэдий олон зүгт туяа гэрлээ цацраадаг ч угтаа нэг л эх сурвалжтай байдаг. Бид ч мөн тийм. Энэ нэгдмэл чанар хүнд бас нийгмийн амьдралд ч байдаг. Оюун сэтгэлийн энэ тэнгэрлэг хууль хүний нийгэм, улс төр, эдийн засгийн амьдралын хувьд түгээмэл үйлчилдэг бөгөөд бүхнийг нэгтгэж байдаг.

Тэрээр мөн дахин төрөл авах явдалд итгэж байв. Энэ нь түүний Хинду соёлын итгэл үнэмшил ба уламжлалыг туйлаас хүндэтгэж байсантай холбоотой. Хиндуизмд дахин төрөл авах гэдэг нь төрөхөөс өмнөх ба үхсэний дараах амьдралын нууцыг тайлбарлах метафизик үзэл баримтлалтай холбоотой. Ганди үүнийг ор үгүйсгээгүй боловч мөн гүнзгий судлаагүй юм. Энэ үзэл нь хүнийг атаархал, өс хонзон, зөрчил тэмцэл дунд ч үнэнч, сайхан сэтгэлтэй, хайраар дүүрэн, ёс суртахуунтай байхыг сургадаг. Амьдрал бол сарнайн орон биш. Үүнд мөн тэмцэл, зовлон зүдгүүр байдаг. Ихэнх тохиолдолд хүмүүс эдгээртэй тулгарахдаа уналтанд ордог.

Гэвч хойд насны амьдралд итгэх нь хүмүүний шинэ хараа, боломжуудыг нээж өгдөг байна. Энэ ертөнц бүх зүйлийн төгсгөл биш бөгөөд өнөө үйлдэж буй зүйлс нь ирээдүйн амьдралд хамааралтай гэдгийг ухаардаг. Энэ насны амьдралд тохиолдож буй муу муухай зүйлс, зовлон бол бүх зүйлийн төгсгөл биш гэсэн сйлголт нь хүмүүст амьдралын эрч хүчийг өгдөг. Дахин төрөл авах явдалд итгэх нь ёс суртахуун, шударга амьдралын нөхцлийг бий болгодог. Дахин төрөл авах явдал нь Кармад буюу үйлийн үрд итгэх итгэлтэй холбоотой. Бас ёс суртахууны нэгэн дүрэм болсон "хүн юу тарина түүнийгээ хураана" гэсэнтэй үүнийг холбож ойлгож болно. Эртний Энэтхэгийн сэтгэгчид хүний амьдралын зовлон зүдгүүр нь өнгөрсөн төрөлдөө хийсэн муу үйлээс үүдэлтэй бөгөөд энэ амьдралдаа сайн сайхан зүйл хийвэл ирээдүйд түүний үр дүн нь сайн байх болно гэж үздэг. М.Ганди кармагийн энэхүү үзлүүдийг хүлээн зөвшөөрч баримталж байжээ.

Түүний үзлээр, "оюун ухаан, бие махбодийн байдлаараа хүн бол цор ганц юм, одоо байгаа хувь хүний байдал нь түүний хийсэн үйлдэл, яриа, мэдрэмж бодол зуршлын үр дүн бөгөөд хүн өөрийгөө эдгээр гадаад дотоод үйл ажиллагаагаараа бий болгож байдаг. Эдгээр зүйлс нь дангаараа тийм ч чухал нөлөөтэй биш боловч хүний зан чанар, эрүүл мэнд цаашлаад бүхэл хувь заяаг шийдвэрлэдэг байна". М.Гандигийн хувьд кармын хууль ёс суртахууны хувьд маш ач холбогдолтой. Кармаг мэдсэнээр ирээдүйн мөн чанараа тодорхойлж болох бөгөөд хүн бол өөрийн хувь заяаг жолоодогч гэдгийг ухамсарлуулж байдаг төдийгүй үүрэг хариуцлагыг нь мэдрүүлж байдаг. Иймд хүний цаад уг чанарт тэнгэрлэг мөн чанар байдаг бөгөөд өөрийгөө ухамсарлах нь тус мөн чанараа илэрхийлж буй хэрэг гэсэн байна.

М.Ганди хэлэхдээ "Би энэ дэлхийд шинээр юу ч хийгээгүй. Үнэн, хүч үл хэрэглэх зарчим угаасаа л байсан зүйлс. Би өөрийн амьдралын алдаанаасаа суралцаж, өөрийн бодол санаагаа төлөвшүүлсэн. Амьдрал надад ингэж үнэн ба хүч үл хэрэглэх зарчимд суралцуулж мэдлэгийг өгсөн бөгөөд үнэний тухай эрэл хайгуулаасаа би хүч үл хэрэглэх зарчмыг олсон юм. Өөрөөр хэлбэл, энэ нь үнэний тухай төсөөллөөс ахимсад шилжсэн шилжилт байсан" гэжээ. Тэрээр "ахимса, үнэн хоёр нь салгаж болшгүй нягт холбоотой зүйлүүд буюу нэгэн зоосны хоёр тал лугаа салгаж болшгүй ижил утгатай юм. Ахимсагийн хувьд үнэн

бол төгсгөл. Иймээс ахимса бол бидний хамгийн дээд үүрэг хариуцлага зорилго. Ахимсаг хөгжүүлж чадвал хэзээ нэгэн цагт үнэнд хүрэх болно.

Тэрээр "Ахимса"-г өөрийнхөөрөө тодорхойлжээ. Түүний үзлээр, "ахимса нь эерэг болон сөрөг хоёр талтай. Эерэг тал нь түүний үзэл бодлын суурь болж байсан ба энэ нь сөрөг байдал болон ахимсагийн мөн чанарыг илэрхийлдэг. Ахимсагийн гол утга нь аллага үйлдэхгүй байх явдал байдаг. Ахимсагийн эсрэг зүйлийг химса хэмээн нэрлэдэг. Химсагийн уур уцаар, хувиа бодсон сэтгэл, муу сэтгэлээс болж өвчин зовлон, аллага бий болдог бөгөөд эд бүгдээс цээрлэх нь ахимса юм.

Түүний энэ үзэл нь жайнизмын үзлээс эхтэй болохыг харуулж байгаа болно. Жайнистуудын хувьд муу зүйлийн тухай бодох хүртэл хориотой байдаг, хэн ч муу зүйл хийхгүй байхыг шаарддаг. М.Гандигийн хувьд жайнизм дахь энэ хатуу шаардлага нь боломжгүй гэж үзэж байв. Тэрээр зайлшгүй нөхцөлүүдэд химса гарцаагүй тохиолддог гээд, уух, идэх, алхах, амьсгалах зэргээр жишээ татсан байна. Хэн нэгний биеийн тусламжгүйгээр, гэмтээлгүйгээр зарим зүйлсийг хийх боломжгүй. Гарцаагүй нөхцөл байдлын дор амь хөнөөх тохиолдол байж болно. Амь хөнөөнө гэдэг үүрэг байж болно. Тухайлбал, хоолны төлөө ургамал таслах, эрүүл мэндийнхээ төлөө шумуулыг алах гэх мэт. Үүний адилаар алан хядлага ч бас ямар нэгэн үйл явдал хэн нэгний тулд зайлшгүй хэрэгтэй байж магадгүй юм. Хэн нэгэн гартаа сэлэм бариад, уур хилэнтэйгээр явж байтал хэн ч түүнийг зориглож барихгүй, харин хэн нэг хүн түүнийг дуусгаж гэмээнэ олны талархлыг хүлээж сайн үйл хийсэн хэмээн хэлэгдэх гэх зэрэг жишээнээс зайлшгүй нөхцлийг тэрээр хүлээн зөвшөөрсөн байна. Түүний үзлээр, амьтны амь хөнөөх, хүчирхийлэл үйлдэнэ гэдэг нь уур хилэн, бардамнал, өс хонзон, хувиа бодох, муу санаа зэргийн үед бий болох хүчирхийллийн хэлбэр юм. Энэ бол Химса бөгөөд Ахимса хэмээх ойлголтын эсрэг сөрөг зүйл юм. Ахимса бол ердөө зөвхөн хүн амьтныг хөнөөх, гэмтээхээс татгалзах бус, энэ бол бусдын амьдралыг эерэгээр харан гэгээрч буй хэрэг юм.

Ахимсагийн эерэг талыг М.Ганди голлон авч үзсэн бөгөөд тэр нь түүний итгэл үнэмшлийн үндэс бөгөөд хүн төрөлхтөнийг илэрхийлэх үнэлэмж болдог билээ. Амьдралд хүчирхийллийн орших газар үгүй гэдэг бол утгагүй үнэндээ бид бусдын амьдралыг адилхан хайрлаж, химса болон бусад муу муухайг авч хаян, Ахимсагийн зарчмыг амьдралд мөрдөх нь хараахан болоогүй. Бид юу ч үгүй байж хүчирхийллийг хийж чаддаг.

Хэнд шударга чин сэтгэлийн угаас хандах зан байж, өөрөөсөө ховдог шунахай, шударга биш зангаа гарган хаяж чадна тэр хүн үзэл бодолдоо тууштай байдаг, бусдад хор хөнөөл хүргэхээс зайлсхийхээс гадна бусдад сайн үйл хийх эерэг хандлага бий болгоход ахимсагийн мөн чанар оршдог байна. Иймээс Ахимса бол хүн төрөлхтний гол мөн чанаруудын нэг юм. Хүчирхийллийн үр дүнд бий болсон зүйл мөнх байдаггүй. Хүмүүс нүгэл, өс хонзонгоосоо болж зовж шаналдагийг түүх бидэнд заасаар ирсэн.

М.Гандигийн энэхүү үзэл нь ахимса бол хүний мөн чанартай холбоотой гэдгийг илэрхийлж байна. Бид хэдийгээр эхний үедээ хэрцгий хүч нь ноёрхсон харагдах боловч хувьслын үр дүнд ахимса руу чиглэдэг. Ямарч амьтан ямар нэг юм тохиолдоход өөрийн үр удмаа үгүй хийж, идэж чадахгүй, хүн ч мөн үүний адил юм. Хүн бол бие махбод оюун ухааны нэгдэл мөн. Биеэрээ юмсыг хийх авч, ухаанаараа хүчирхийлэл үйлдэгч биш. Бие гэмтдэг ч харин оюун санаа хэзээ ч гэмтэхгүй. Иймээс химса хүний жинхэнэ мөн чанар биш.

Ахимсагийн эерэг талыг хайргүйгээр төсөөлөх аргагүй. Хайр бол сэтгэлийн нэг хэлбэр бөгөөд хүн өөрөө хайрын объект байдаг. Ахимса нь атаархал, өс хонзон, үзэн ядалт, хорсол, уур зэргээс чөлөөлөгдсөн чин

сэтгэлийн хүчин чармайлт, чөлөөт оюун санааг шаардаж байдаг. Учир нь эдгээр нь хайрыг бий болгоход тохиолддог саад бэрхшээл юм.

Хайр гэдэг бол дотоод сэтгэлээ ариусгах хүч бөгөөд энэрэл хайр, нөхөрлөл, нинжин сэтгэл, тэвчээр, өршөөл уучлал, нигүүлслийг төрүүлдэг. Хайр бол хэцүү зүйл. Яагаад гэвэл үзэн ядах амархан мөртөө үүнийг хайр болгоход маш их хүч чадлыг шаардаж байдаг. Энэ талаар М.Ганди хэлэхдээ: "Хүч үл хэрэглэнэ гэдэг бол хүчирхэгийн шинж. Харин хүчирхийлэл гэдэг нь сул доройн шинж. Хүний дотор үүсэх сул дорой байдал нь айдсыг бий болгож, айдас өөрийг нь дайсныхаа урдаас зэвсэг барихад хүргэдэг. Хүчирхийлэл харагдах байдалдаа маш хүчтэй байж болно, гэвч айдсаас төрсөн учраас энэ нь сул доройн шинж байдаг. Өөрийн айдсаа дарж чадсан хүн л үнэн хүч үл хэрэглэх зарчимтай хүн байдаг. Хөнөөх чадал бол хүч чадлын илэрхийлэл биш, харин үхэх чадал бол хүчтэйн шинж байдаг. Аллага хэрэглэх нь үнэн хүч биш бөгөөд ийм хүч үнэн хүчний өмнө нь өвдөг сөгддөг. "Арчаагүй дорой хулгана хүртэл хүч хэрэглэгч байдаг. Учир нь тэр үргэлж мууранд идүүлдэг тул хэрэв тэрээр муурнаас хүчтэй бол муурыг баяртайгаар идэх болно". Ахимсад суралцсанаар өрсөлдөгчөө дийлэх хүчийг олж авах бөгөөд ахимса бол өс хонзон авах гэсэн хүслийг цээрлэх хүч юм. Үнэндээ амьдрал дээр агуу их хайрын хүчээр хождог. Энэ бол жинхэнэ хүч юм. Хүч үл хэрэглэх зарчим бол хүч хэрэглэгчийн өмнө бууж өгөхийг гол болгодоггүй, харин харгис дарангуйлагчийн эсрэг зогсох сэтгэлийг бий болгодог юм.

Хүч үл хэрэглэнэ гэдэг бол золиос болон хүний зовлон гэгч зүйлтэй холбоотой байдаг. Золиос бол Хайртай хамт байдаг. Хайр бол авах биш өгч байх ёстой зүйл. Тэрээр хэлэхдээ "хайр юу ч шаарддаггүй, хайр хэзээ нэгэн цагт зовоодог ч, хэзээ ч өс хонзон санадаггүй гэсэн байдаг. Иймээс хайр зовлон гэгч ойлголттой холбоотой байдаг. Хайрын шалгуур бол "өөрөө зовохуй" юм. Зовлон шаналал бол амьдралын дайнд ялах арга зам" гэжээ. Бид зовж байсан ч цаг хождог ингэснээр дайсандаа түүний уурыг намжих цаг өгч байна гэсэн үг. Тэр тэгээд өөрийнхөө алдааг ойлгох болно.

Тиймээс дайснаа ч гэсэн адилхан хайрлаж байх нь түүнд нинжин сэтгэлээр бэлэг барьж байх нь түүний зовлон шаналалыг мэдэрч буй хэрэг юм. Иймэрхүү зовлон шаналал үгүй бол дэмий хоосон зүйл болно. Ингэхлээр зовлон шаналал яагаад хайрын нэг элемент вэ гэх асуудал гарч ирэх ба хайрын мөн чанар бол жаргал цэнгэл биш, зовлон шаналал юм гэжээ. Түүнчлэн хүч үл хэрэглэх гэдгийг хайр, зовлон шаналалаар төсөөлж, энэ нь өөрийгөө хүндэтгэх мэдрэмжийг өгдөг.

М.Ганди хэлэхдээ: "Өршөөл уучлал бол дайснаа ичгүүртэйгээр шийтгэх хамгийн дээд арга мөн. Ахимсаг бүх газарт, бүх цаг хугацаанд эрэгтэй эмэгтэй, хөгшин залуу, хүүхэд томчуул бүгд хэрэгжүүлж чадна" гэжээ. Ямарваа үндэстэн, нийгэм, хувь хүн бүр чин сэтгэлээсээ хандах тэр үед Ахимса бүрэн биеллээ олно гэж тэрээр үзэж байлаа. Ахимсагийн үйл ажиллагааг бурханд тууштай итгэж амьдрахтай юун түрүүнд холбох хэрэгтэй. Ахимса нь маш их дотоод сэтгэлийн хүчийг шаардах ба ийм хүчийг зөвхөн бурханд итгэснээр л олж авдаг. Бурханд үнэн сэтгэлээсээ итгэснээр бусдыг эерэгээр харж сурдаг. Бурхны хайр нь нийт хүн төрөлхтний хайр бөгөөд ингэснээр ахимсад хүрч чадна. Энэ бол хүн төрөлхтний эв нэгдлийг ухаарч чадсаны үр дүн ба бурханд сүсэглэх нь ахимсагийн хамгийн чухал зүйл.

Тэрээр ахимсад хүрэх арга барилыг сагъяаграха буюу үнэнийг баригч, үнэний хүч, хайрын хүч, сэтгэлийн хүч гэж нэрлэжээ. Зөвхөн энэ хүчийг эзэмшин гэгээрч чадсанаар хүн хүчирхийллээс зайлсхийж чадах юм. Түүнчлэн үнэн нь хүч тэнхээтэй хайр ба гүн гүнзгий сэтгэлээс хамааралтай. Энэ нь бурханд хүрэх зам ба үнэнийг илэрхийлэх зам болно. Бурханд хүрэх зам ба үнэний зам гэдэг

нь сатьяграха дахь хатуу журам болно. Энэ нь Сатьяаграха үндсэндээ хайранд суурилдаг гэсэн үг.

Эндээс харахад М.Гандигийн шашны үзэлд бүхний цаана бурхан байж, бидний дэргэд ч бурхан оршдог гэсэн санаа бий. Хүн төрөлхтөнг хайрлах хайргүйгээр хэн нэгэн сатьяаграхад суралцаж чадахгүй. Сатьяаграха нь үнэнийг ямар нэг ашиг хонжоо, давуу тал хайлгүйгээр чин сэтгэлээсээ эрэхийг шаарддаг. Гэвч энэ нь хутганы ирэн дээр явахтай адил хэцүү бөгөөд хэн нэгэн одоогийнхоо биш дараагийнхаа амьдралд энэхүү сайн үйлийнхээ үр дүнг хүртэж чадна гэж итгэх үед л чадах болно.

Сатьяаграха бол шударга бус явдал болон харгислал, хүчирхийллийн эсрэг хүч мөн. Энэхүү бүх бузар муухай юмс нь үнэнийг үл ойшоож, ойлгож ухаараагүйгээс үүсдэг. Түүнчлэн М.Ганди хэлэхдээ "хэрвээ бид хүчирхийллийг хүчирхийллээр, уурыг уураар, бузар муухайг бузар муухайгаар эсэргүүцэж эхэлбэл энэ нь гал дээр тос нэмсэн хэрэг болно. Тэдгээр муу муухайгийн эсрэг хамгийн үр дүнтэй зэвсэг бол сатьяаграха юм. Энэ нь дайсан чинь алдаагаа ойлгож өөрчлөх хүчийг өгөх ба түүгээр түүний амьдралыг засаж залруулдаг байна. Энэ нь хэрэг хийгчид өөрт нь суурилах ба түүний доторх өөрийнх нь нинжин сэтгэлийг сэргээх үйл явц юм. Яагаад гэвэл хүн бүрийн дотор бурхан байдаг. Аливаа муу явдал нь хүн өөрт байх сайн чанараа үзэн ядалт зэрэг муу зүйлээр хучсанаас үүсдэг гэсэн байна. Энэ нь хүний сайн үзэл бодлыг сэргээхийг шаарддаг гэсэн үг. Ингэснээр хувь хүн өөрөө хийсээр ирсэн зүйлийнхээ бурууг ойлгох болно. Сатьяаграха нь хүнийг өөрийг нь үнэний төлөө зовж шаналж чадахаар болгодог. Ахимса бол ухамсарт зовлон юм.

Түүнчлэн сатьяаграха бол зовж шаналж түүгээрээ дайснаа хувиргаж өөрчлөх юм. М.Ганди хэлэхдээ "тус тусдаа олон үндэстэн өөр зовлонтой ба түүнийг гэтлэх аргыг хайж байдаг. Баяр хөөр бүхэн бусдын зовлон дээр суурилсан байдаг гэхдээ энэ нь хэн нэгнээр хязгаарлагдсан байдаг" гэжээ. Албадлага бол хүчирхийлэл, энэ бол биеийн албадлага биш гэхдээ жаахан сэтгэлийн дарамт байж болох юм. Сатьяаграхагийн зорилго нь буруу үйл хийгчийг ичээж сандраах биш юм. Энэ нь айдас түгшүүрт уриалдаггүй, сүрдүүлэг заналыг бий болгодоггүй. М.Гандигийн үзлээр, энэ нь "зүрх сэтгэлд нь өөрчлөлт"-ийг бий болгодог. Сатьяаграха үзлээр, дайсан, өрсөлдөгч гэж байдаггүй, зөвхөн буруу үйл хийгчид л байдаг байна. Буруу үйл хийгчид алдаа хийдэг, биеийн хүчээ буруугаар ашигладаг, гэхдээ тэд буруугаа ойлгосон үедээ өөрөө түүнийгээ засч, харамсдаг.

Сатьяграха нь хайранд суурилдаг. Хайр нь дайсанд ч бас адилхан үйлчлэх ёстой. Эргэлзээ ба үзэн ядалтыг даван туулах нь сатьяграхад хүрэх арга зам мөн. Дайснаа хүндэтгэх хүндэтгэл байх ёстой. Сатьяаграха нь буруу үйл үйлдэгсдэд муугаа хаяхыг итгүүлснээр дайсан ч бас хайр хүндэтгэлд ойртох болно гэж сургадаг. Сатьяаграха нь маш их тэвчээрийг шаардах ба буруу үйл хийгчид нь хийсэн буруугаа засаж чадахгүй байхаас буруугаа хүлээх хүртэл тэр хугацааг өөртөө агуулж байдаг.

Сатьяаграха "идэвхгүй эсэргүүцэл" –ээс дараахь байдлаар ялгагддаг. Үүнд:

- Сатьяаграха бол идэвхгүй байдал биш, хүчирхийллээс ч идэвхтэй байдаг,
- Идэвхгүй эсэргүүцэл нь хүчирхийллийг бүрэн хориглодоггүй ба энэ бол . . . хүн хөрөглөх байдлын нэг элемент. Сатьяаграха бол хүчирхийллийг бүрэн хориглодог.
- Идэвхгүй эсэргүүцэл нь үргэлж найз нөхдөө зовоох түгшээх сэдэлд оруулдаг бол сатьяаграха нь гачигдал зовлонгоо хамтран үүрч дайснаа гэмтээх өчүүхэн ч сэдэл байдаггүй.
- Идэвхгүй эсэргүүцэгчид хуульд захирагддаггүй бол сатьяаграха нь түүнд

хүндэтгэл үзүүлэх сэтгэлийг бий болгодог. Өөрөөр хэлбэл, сатьяаграхад бурхан ба үнэний хууль нь эрхэм дээд хууль байдаг. Үнэндээ сатьяаграха бол бүхэл бүтэн хүндэтгэл юм.

- Идэвхгүй эсэргүүцэлд хайрын талаар тийм ергөн цар хүрээтэй байдаггүй бол сатьяаграхад үзэн ядалтын орон зай байдаггүй. Идэвхгүй эсэргүүцэл нь эсрэг байх найз нөхдийн бус байдал дээр суурилдаг байхад сатьяаграха нь хайр дээр үндэслэдэг.
- Идэвхгүй эсэргүүцэл нь ямар нэг юмыг хийхийг албадах албадлагын хэлбэр бөгөөд хүний зүрх сэтгэлийг өөрчлөхийг хичээдэггүй. Сатьяаграха нь хүний зүрх сэтгэл, оюун санаа, түүний үзэл бодлыг уг үндсээр нь өөрчлөхийг зорьдог. Сатьяаграхагийн мөн чанар бол дайсагналыг устган дайсагналцалгүй байх байдал юм.

Ийм маягаар сатьяаграха нь хайр болон ахимсад итгэх итгэл үнэмшил ба нүглийн хор хөнөөлийг зовлонг мэдэрснээр арилгадаг. Иймээс энэ бол үнэний зам юм. М.Гандигийн энэ арга түгээмэл бөгөөд байгаль ба нийгэм, саланги ба нэгдмэл, эрэгтэй ба эмэгтэй, хүүхэд хөгшид ялгалгүй энэ аргад суралцаж чаддаг. Ураг төрөл, улс төр, айл гэрийн амьдралд ч адилхан үйлчилдэг.

Гэвч энэ арга барилыг бүх хүн хэрэгжүүлэх боломжтой авч чин сэтгэлээсээ хийхгүй бол болохгүй гэж М.Ганди үзэж байв. Энэ маш чанга хатуу нарийн ёс суртахуун, сүсэг бишрэл бүхий сахилга бат, дэг журам шаарддаг.

Сатьяаграха дараах чанарыг бүрдүүлсэн үед хэрэгжих боломжтой. Үүнд:

- Сатьяаграха нь чин сэтгэлтэй, үнэнч шударга байх ёстой.
- Сатьяаграха ямагт нээлттэй байх ёстой.
- Сатьяаграха ямагт дэг журамтай цэрэг шиг байх ёстой. Цорын ганц үнэн бол түүний багш нь ухамсар байдаг.
- Сатьяаграха төгс эрхэм байх ёстой. Үхлийн өмнө ч эрэлхэг байх ёстой. Айдсаа даван туулж чадахгүй бол түүнийг хэрэгжүүлж чадахгүй.
- Эр зориг нь сайн санаа, амь биеэ зориулах өөр нэгэн зүйл рүү хөтөлдөг. Сатьяаграха амь биеэ зориулах агуу зүйлд бэлтгэгдсэн байх ёстой. Тэр өөрөө төгс агуу зүйл. Тэр үнэний төлөөх агуу зүйлд, зовлон зүдгүүрийг амсахад бэлтгэгдсэн байх ёстой.
- Зовлон зүдгүүр ба амь биеэ зориулах нь энгийн байх ёстой. Хэрэв Сатьяаграха нь бардам болбол агуу хүчирхэг ямар нэгэн зүйлийг хийх талаар мэдэрч эхэлбэл үр дүнгүй болно. Төлөв төвшин байдал даруу зан бол Сатьяаграха -ын нэг сайн чанар юм.
- Сатьяаграха нь үнэн байдал, хүч үл хэрэглэх байдал нь зөвхөн үйл төдийгүй сэтгэл үг бүрт байх ёстой гэдэг.
- Шударга байдлын хувьд дэгтэй хатуу чанга байх ёстой. Тэр шударга бус ятгалга, шуналт хомхой сэтгэлтэй байх ёсгүй гэж үздэг. Шийдэмгий хатуу сэтгэлийн тэнхээ, дотоод сэтгэлийн тамир тэнхээтэй байх ёстой.
- Сатьяаграха -ын үйл хэрэг болон бодол хоёр нь хоорондоо нийцэж байх ёстой. Эдгээрийн зөрчлөөс муу зүйл төрөн гардаг. Юу хэлж юу хийж байх нь ямагт холбоотой байх ёстой.
- Сатьяаграха нь өөрийгөө барьж дийлэхийг сурах ёстой. Тухайлбал, мацаг барих нь өөрийгөө барих хянахыг сурах нэг арга мөн.
- Тэр нь буян үйлдэж, нүглийг тэвчих явдал байдаг.
- Сатьяаграха нь хүлцэнгүй байх ёстой. Хэрэв хүн хүлцэнгүй байхгүй бол өөрийгөө хянах чадвараа алдах ба Хайрыг хүртэж чадахгүй.
- Дэг журам бол зарчим бөгөөд өөрийгөө хянах хүчийг олоход тусладаг.
- Сатьяаграха нь бурхныг шүтэн амьдрах ёстой гэж үздэг. Эдгээр шаардлагыг хангаж чадвал сая зорилгодоо хүрэх юм.

Сатьяграхагийн хэлбэрүүд нь хэлэлцээр, эсэргүүцэл бослого, мацаг барих, иргэдийн үл захирагдах байдал, хөндлөнгийн шүүх, эдийн засгийн хаалт, хамтын ажиллагаанаас татгалзах, шууд арга хэмжээ авах зэрэг болно. М.Ганди эдгээр хэлбэрийг бүгдийг нь хүлээн зөвшөөрдөггүй. Харин ч заримыг нь /шүүмжилж/ няцаадаг байв. Тухайлбал, Сатьяграхийн хэлбэрүүдийн байж болох гажуудлыг мэддэг. Тэрбээр эрх баригчдыг эсэргүүцэх нь хууль ёс завхарч, эрхээ хэтрүүлэн эдлэх явдалд, эцэстээ дотроосоо сүйрэхэд хүрнэ гэжээ. Тэр хэрвээ зорилго нь тодорхой бус бөгөөд хайрын хүчээр хийгдээгүй л бол эдгээр хэлбэр бүтэлгүйтэх болно гэжээ.

М.Гандигийн үзлээр, Сатьяграхыг хэрэгжүүлэх хэлбэр нь хүн хүний хувьд өөр байж болно. Тэрээр Сатьяграхаг дэлхий дахинд хүлээн зөвшөөрөгдсөн зарчим гэдэгтэй санал нийлдэг ба харин хэрэгжүүлэх хязгаарыг нь бүхэл бүтэн үйл явц гэж боддог. Гэвч тэр үүнийг хэрэглэхэд зориулж үндсэн бөгөөд чухал шаардлагатай нөхцөлийг гаргасан. Энэ нь хүн бүр сайхан сэтгэлийн үндсэн дээр өөрийн сүнсний оршихуйг таньж мэдэх явдал юм. Ингэж сүнсээ таньж мэдэх нь оюун ухааны ойлгоц төдийгүй бидний амьдрал, үйл ажиллагааны үндэс суурь нь болж байдаг амьдралын хувь тавилан юм.

М.Гандигийн хувьд Сатьяграхын гол хэлбэрүүд нь үл захирагдах, хамтын ажиллагаанаас татгалзах, шууд арга хэмжээ авах, мацаг барих аргууд юм. Үл захирагдах ёсыг шударга бус хуулийн эсрэг тэмцэл хэмээн үздэг. М.Ганди энэ арга барилыг голдуу өмнөд Африкт шударга бус явдал, арьс өнгөөр ялгаварлан гадуурхсан агуулгатай хуулиудын эсрэг тэмцэх үедээ хэрэглэж байжээ. Хамтын ажиллагаанаас татгалзах хэлбэр нь бусдыг ашигласан талыг ингэж ашиглахын эсрэг эсэргүүцлийн хэлбэрт хүргэдэг. М.Ганди бусдыг ашигласан тал бол улам ашиглахыг эрмэлздэг гэж үздэг. Учир нь тэр өөрийгөө Үл дагах нь мөлжлөгөөс татгалзаж, мөлжлөгийн хүчинд автахас холуур байлгадаг. Шууд үйлдэл нь нээлттэй, жин нөлөөтэй эсэргүүцэх хэлбэр болж чаддаг. Хэдийгээр эсэргүүцэх гэдэг нь хүчирхийллийн өнгө аяс агуулж байгаа мэт боловч шууд үйлдлээс урган гарах эсэргүүцэл нь үнэн хэрэгтээ харин ч хүчирхийллийн бус байдаг. Түүнчлэн энэ нь маш нээлттэй, учир битүүлэг зүйл агуулдаггүй.

1942 онд М.Гандигийн гаргасан "ТАЙВАН ЭНЭТХЭГ" уриа нь Сатьяграхагийн энэ төрлийн нэгэн жишээ юм. Түүний үзлээр, Сатьяграхагийн хамгийн үр дүнтэй хэлбэр мацаг барих ёсон ажээ. Мацаг барих нь өөрийгөө ариусган цэвэршүүлэхэд болон өөрийн биеэс сөрөг бүхнийг зайлуулан үхлийн замаа сонгоход чиглэгдсэн хоёр аргаас бүтнэ. Мацаг барих нь хүч чадлаа зүрх сэтгэлдээ төвлөрүүлж, өрсөлдөгчөө ялан дийлэх арга замыг олоход тусладаг. Тэрээр зүрх сэтгэлээ чангалж бие махбодио захирна гэдэг бол миний нэгэнт тогтсон гуйвашгүй итгэл бишрэл гээд цааш нь хэлэхдээ "Миний шашин надад холдуулж болохгүй мөртлөө мөргөж залбирахгүй байхын аргагүй зан үйл байх ёстойг үргэлж зааж сургаж байдаг" гэжээ.

Ёс суртахууны үзэл баримтлалын хувьд М.Ганди "хэрэв үйл ажиллагаа нь зөв байвал үр дүн нь сайн байдаг" гэсэн зарчмыг баримталдаг. Үйл ажиллагаа ба үр дүн хэмээх хоёр ойлголт нь М.Гандигийн хувьд түүний философийн үзэл бодолд төв байр суурь эзэлдэг.

Түүний хувьд үнэн шашин хийгээд үнэн ёс суртахуун гэдэг бол салгаж болшгүй зүйл. Шашин бол хүний өөрчлөгдөшгүй мөнхийн шинж чанарын илэрхийлэл. Амьтны зэрлэг шинж нь хүний мөнхийн шинж билээ, харин хүнд байдаг жинхэнэ шинж бол тэнгэрлэг чанар юм. Хүн бүрийн дотоодод сайн чанар бий. Шашин бол хүнд байдаг сайн чанарын илэрхийлэл. Шашин бол хүнийг сэтгэлийн завгүй байдлыг бий болгож байдаг. Учир нь сайн ба зөв зүйлийг хүмүүс бий болгон хөгжүүлэхийг эрмэлздэг бөгөөд энэ нь хүнийг ёс суртахуунтай болгож байдаг. Шашин ямагт үнэний төлөөх эрмэлзэл болоод чин хайр

ухамсартай холбоотой. Энэ бүгд байхгүйгээр шашин үр дүнгүй зүйл болж хувирна. Иймээс Үнэн ба зөв зүйлгүйгээр ямар ч шашин байх бололцоогүй гэжээ.

М.Гандигийн хувьд шашин бол хүний сониуч зан хүсэл тэмүүлэлд нийцүүлэхийг эрмэлзсэн онолын ойлголт төдий зүйл биш юм. Шашин хүнд амьдралын үйл явдлыг бодож шийдэхэд нь туслахгүй бол тэр шашин биш гэж үздэг. Мөн тэр хэлэхдээ “шашин бол амьдралыг тал бүрээс нь хамарсан байх хэрэгтэй бөгөөд улс төрийн амьдралд ч мөн адил” гэж үздэг. Түүний үзлээр, шашин бол орчлон ертөнцийн эмх цэгцтэй ёс суртахууны итгэл үнэмшил юм.

Залбирал нь үнэ цэнэтэй маш чухал зүйл: жишээ нь сэтгэл хямарсан үедээ чимээгүй бясалгал хийж ганцаараа байсны дараа эрч хүчээ сэргээж хүч чадал итгэл үнэмшлийг олж авдаг. Мөргөл залбирал нь энх амгаланг авчрах арга зам. М.Ганди хэлэхдээ: “Залбирал нь шашны мөн чанарт хүрэх арга зам юм”. Бурхан бол хүн бүхний дотор нь байдаг. Түүний зөвшөөрөлгүйгээр юу ч бий болдоггүй. Түүний дэмжлэггүйгээр бид хэн ч биш. Үүнийг өөрийнхөө доторыг ариутгах гэж нэрлэж болно. Залбирал нь биднийг ариутгаж бурханд илүү ойр болгож өгдөг. Мөн бид хүч чадлыг олж авч бие биенийхээ зовлонг хуваалцдаг”.

Түүний үзлээр, “Шашин нь хүний оюун санааг сэргээх хүчин зүйл юм. Мөн тэдний бие махбод мэдрэхүйг шалгах чухал зүйл бөгөөд амь бие хайрлахгүй байх чанарыг шаарддаг. Гэхдээ энэ нь оргож зайлах амиа аврах татгалзал биш юм”. Аливаа хүн хувийн сонирхлоосоо шалтгаалан амьдралынхаа замыг сонгодог. Хэрвээ хэн нэгэн хүн өөрийн итгэдэг шашнаа шүтэх эрх чөлөөтэй бол тэр бусдын сонгосон шашин хийгээд бусдын үзэл бодлыг хүндэтгэн үздэг хүлээцтэй ханддаг байх ёстой. Тиймээс М.Ганди аливаа шашинд хандахдаа тийм адил хүндэтгэн үзэж, хүлээцтэй хандахыг зөвлөдөг. Бүхий л шашин сайн сайхан амьдралыг хүсэж, хүнлэг энэрэнгүй шулуун шадарга байхыг номлодог гэдэгт тэрээр итгэж байлаа.

“Маш олон жилийн судалгаа, туршлага зэргээс үндэслэн би нэгэн дүгнэлтэд хүрсэн. Бүх шашинд үнэн юм, бас өөрийн гэсэн алдаа байдаг. Гэхдээ бүх шашин миний Хинди шашин шиг хүнлэг энэрэнгүй байхыг сургадаг. Тиймээс хүн төрөлхтөн бүгдээрээ хамаатан садан юм. Иймээс бие биедээ халуун дотно ханддаг байх хэрэгтэй гэжээ. Хүний гол зорилго нь Хинди шашинтан нэг хүнийг илүү сайн Хинди хүн болоход нь, Мусульман шашинтан нэг хүнийг илүү сайн Мусульман хүн болоход нь, Христ хүнийг илүү сайн сайхан Христ хүн болоход л нь туслахад оршино. Найз нөхдийнхөө шашин шүтлэгийг харгалзахгүйгээр тэднийг зөвхөн сайн хүмүүс болохыг ерөөж, залбирч мөргөх хэрэгтэй” гэж тэр үздэг.

Бид ертөнц дээрх хүн төрөлхтөн, бүх амьтдыг хайрласнаар үнэнг ухаарна хэмээн М.Ганди хүний амьдралын зорилгыг тодорхойлжээ. Тэрээр хүч үл хэрэглэх зарчим нь өөрийгөө бүрэн ойлгон ялах явдал бөгөөд энэ нь Атманы¹⁰⁴ хүч. Уур хилэн бол Ахимсагийн дайсан, хүн дайснаа хүртэл үзэн ядахгүй байж, нүгэлтнийг бус нүглийг үзэн ядах хэрэгтэй гэжээ. Хүч үл хэрэглэх зарчим бол үнэнч, өөрийгөө захирах чадвар, зориг хүлцэнгүй байдал, өршөөл зэргийг нэгтгэж уур хилэн, үзэн ядалтаас ангид байх явдал байдаг.

М. Гандийн хувьд хүч үл хэрэглэх зарчим нь ёс суртахуунгүй байдлын эсрэг ёс суртахууны цохилт бөгөөд олон улс үндэстэн, шашин, эдийн засаг, нийгмийн муу бүхний эсрэг ёс суртахууны зэвсэг юм. Түүний үзлээр, энэ бол хувьсгал бөгөөд зэвсэглэсэн хувьсгал биш, оюун ухааны зүрх сэтгэлийн цусгүй хувьсгал юм. М. Ганди нь коммунист, социалист үзэлтэн байгаагүй бөгөөд түүний оронд энэрэнгүй байх бодлогыг нийгэмд хэрэгжүүлэхийг оролдож байв.

¹⁰⁴ Атман- Би хэмээх ойлголт бөгөөд зөвхөн оюун ухаанаар танин мэдэгдэнэ

М. Гандийн хувьд хүчирхийлэлгүй байх нь нийгмийн үндэс суурь бөгөөд нийгэм эмх замбараагүй бус, цус урсахгүй, алдаа төөрөгдөлд автахгүй, харин үүнийг бий болгох нь удаан боловч хэрэгжинэ, хайр бол нийгэмд эв зохицол, аз жаргал бий болгоно гэж итгэж байжээ.

Нийгэмд эрэгтэй эмэгтэй хүмүүсийг адил тэгш хүндэтгэх, хүн бүр бүх шашныг хүндэтгэж байх, хүн төрөлхтний төлөө өөрийгөө золиослоход бэлэн байх ёстой аж. Хүч үл хэрэглэх зарчим буюу үнэнийг танин мэдэх нь зөвхөн хувь хүний ухаарал бус, харин улс төр, нийгэм, эдийн засгийн амьдралд нөлөөтэй гэж үзсэн нь М. Гандийн дэлхийн соёл иргэншил, соёлд оруулсан хамгийн том хувь нэмэр юм.

Ном зүй

- Basant Kumar Lal. Contemporary Indian Philosophy. Delhi. 1995
- D.M.Datta. The philosophy of Mahatma Gandhi. University of Calcutta. 1968